

## ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

**ЛАОС, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ДЭВШЛИЙН ЗАМААР**

(БНАЛАУ-ыг тунхагласны 10 жилийн ойд)

1951 оны эхээр хуралдсан Энэтхэг-Хятадын коммунист намын (ЭХКН) II их хурлаас тус хойгийн гурван орон тус бүрт коммунист нам байгуулах чиглэл боловсруулсны дагуу 1955 оны гуравдугаар сарын 22-нд Лаосын ардын Хувьсгалт Намыг (ЛАХН) байгуулжээ. Энэ өдрөөс эхлэн Лаосын ард түмэн марксизм-ленинизмын үндсэн зарчмыг удирдлага болгосон дайчин манлай удирдагчтай болж, хувьсгалт тэмцлийнх нь түүхэнд эргэлтийн үе эхэлжээ.

ЛАХН ЗХУ, социалист бусад орны интернационалч тусламж дэмжлэгт түшиглэн тэдгээрийн хувьсгалт тэмцлийн баялаг туршлагаас суралцаж, Лаосын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг манлайлан, Лаосын хувьсгалыг хийж эхэлсэн байна. ЛАХН хувьсгалын объектив субъектив тохиргоог бүрдүүлэн, 1975 оны тавдугаар сард ард түмнээ хувьсгалт тэмцэлд удирдан босгожээ. Энэ бослого мөн оны арван хоёрдугаар сард ялалтад хүрч хуучин засгийг хувьсгалаар түлхэн унагааж, Лаост ардчилсан бүгд Найрамдах улсын тунхаглав. Ийнхүү Лаосын ард түмний олон жилийн мөрөөдөл биелсэн билээ.

Лаост үндэсний ардчилсан хувьсгал ялснаар БНАЛАУ социализмд шилжих, капиталист биш хөгжлийн замаар замнах бололцоотой болжээ. ЛАХН дайнд сүйдсэн аж ахуйгаа сэргээн босгох, улс орныхоо нийгэм, эдийн засаг, соёлын хоцрогдлыг даван туулахад чиглэсэн хувьсгалт өөрчлөн байгуулалтын программыг боловсруулан, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны тусламж дэмжлэгт түшиглэн түүнийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

1982 онд хуралдсан ЛАХН-ын III их хурал социализмд шилжихэд шаардагдах урьдчилсан угтвар нөхцөлийг бүрдүүлэх талаар намаас явуулсан үйл ажиллагааг нэгтгэн дүгнээд, социализм байгуулах, эх орноо хамгаалах стратегийн энэ хоёр зорилтыг нягт холбоотойгоор дэвшүүлэн тавьж, 1977 онд хуралдсан Намын Төв Хорооны IV бүгд хурлаас тодорхойлсон шилжилтийн үе дэх Лаосын хувьсгалын гол зорилтуудыг нарийвчлан тодотгож, тус орны нийгэм эдийн засгийг (1981-1985) хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг баталжээ.

Өнгөрсөн хугацаанд Лаосын ард түмэн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж ирлээ. Лаосын эдийн засгийн эх салбар болсон хөдөө аж ахуйг хөгжүүлэх программ амжилттай хэрэгжиж байна. Үүнийг статистикийн дараах хэдэн тоо баримт гэрчилж байгаа юм. 1983 онд хураан авсан нийт ургацын хэмжээ 1976

оныхоос 2 дахин нэмэгджээ.<sup>1</sup> 1984 онд 1.3 сая тонн тутарга хураан авчээ. Үүнийг урьдах оныхтой харьцуулбал 18 хувиар өссөн байна.<sup>2</sup> Ингэснээр улс орны хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж байна. Ой модны асар их баялагтай энэ оронд жилд дунджаар 100 мянган куб метр мод бэлтгэдэг юм. Хөдөөд явагдаж буй хувьсгалт өөрчлөн байгуулалттай уялдан хоршоолох хөдөлгөөн эрчимтэй өрнөж байна. Одоо тариачны өрхийн бараг тал хувь нь 2546 хамтын аж ахуйд нэгдэн оров.<sup>3</sup> Энэ хамтын аж ахуйд бүх тариалангийн 35 хувь нь ногдох болов.

Тариалангийн талбайг усжуулах талаар их анхаарсны үр дүнд 74300 гаруй га-д усжуулах систем ажиллаж байна.<sup>4</sup> Хөдөөд газар тариалангийн болон мал аж ахуйн улсын сангийн аж ахуй, ферм байгуулах, хөдөө аж ахуйг механикжуулах, услалтын системийг өргөтгөхөд ЗХУ, БНСВУ, БНМАУ болон ах дүү социалист бусад орон туслалцаа үзүүлж байна.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл сүүлийн найм-есөн жилд 3.7 гаруй дахин нэмэгдлээ. Тариачны өрхийн худалдан авах чадал сүүлийн хэдэн жилд 4 дахин өсөв. Улсын секторт одоо 217 гаруй үйлдвэр хамрагджээ.

Худалдаа-санхүүгийн үйл ажиллагааг улсын нэгдсэн төлөвлөгөөгөөр зохицуулах болсон нь дотоод зах зээлийн асуудлыг шийдвэрлэхэд түлхэц өгөв. Энэ бүхний үр дүнд тус орны нийгмийн нийт бүтээгдэхүүний ихэнхийг үйлдвэрлэдэг болсон эдийн засгийн социалист сектор улс ардын аж ахуйн гол үндсийг тодорхойлох болов.

Ах дүү социалист орнуудын тусламжтайгаар жил ирэх тутам олон шинэ үйлдвэр, аж ахуйн газар баригдаж ашиглалтад орсоор байна. Зөвхөн ЗХУ ойрын жилүүдэд Лаост улс ардын аж ахуйн зориулалттай 30 объект барьж байгуулах юм. Түүний 16 нь аж үйлдвэрийн барилга байгууламж байх бөгөөд өнгөрсөн хугацаанд ЗХУ буцалтгүй тусламж болгон олон арван барилга байгууламж барьсны дотор Вьентьянд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий больниц, нефть бааз, авто болон хөдөө аж ахуйн механизмын засварын завод, телевиз, телефоны станц зэргийг барьж байгуулжээ.

Үндэсний эдийн засгийн ийнхүү төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх явцад бэрхшээл, саад тотгор багагүй нөлөөлсөн хэвээр байна. Эдгээрээс хамгийн гол нь улс орны тээвэр, харилцаа холбооны асуудлыг шийдвэрлэх нь юу юунаас чухал болж байна. Үндэсний тээвэр, харилцаа холбооны систем бүрэн бэхжээгүй байгаа нь хот хөдөөд таваарын солилцоо явуулахад багагүй бэрхшээл учруулж байгаа юм. Гэвч лаосын ард түмэн энэ асуудлыг бүрэн шийдвэрлэх талаар асар их ажил хийж байна.

Лаосын улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд Меконг мөрний сав газрын нөөц баялгийг ашиглах талаар Вьетнам, Лаос, кампучи хамтран ажиллаж байгаа нь бодит үр дүнгээ өгч байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд Энэтхэг-Хятадын хойгийн ах дүү гурван орон хөдөө аж ахуй, усжуулалт, тээвэр, бүс нутгийн хэмжээний суурь шинжилгээний талаар болон боловсон хүчин бэлтгэх, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны өргөн программ

<sup>1</sup> Правда I. 23, 1984.

<sup>2</sup> "Известия" 17 мая 1985, №137

<sup>3</sup> Мөн тэнд

<sup>4</sup> "Новости Монголии" 22.III 1985.

боловсруулан хэрэгжүүлж байгаа нь орон тус бүрийн улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд үлэмж хувь нэмэр болж байна.

Өнгөрсөн богино хугацаанд соёлын салбарт ч бахдам амжилт олж байна. Нийт улс орон даяар бичиг үсэг үл мэдэх явдлыг амжилттай арилгалаа. Ерөнхий болон тусгай мэргэжлийн дунд сургуульд суралцагсдын тоо 600 гаруй мянгад хүрэв. Үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг ЗХУ, Вьетнам, ах дүү социалист бусад оронд сурган бэлтгэж байна. Зөвхөн ЗХУ-д жил тутам 80-900 лаос охид, хөвгүүд суралцаж байгаа юм.<sup>5</sup>

Эрүүлийг хамгаалах салбарт ч амжилт олж, хот хөдөөгийн хүн ам эмнэлгийн үйлчилгээгээр бүрэн хангагдав. Жил ирэх бүр их эмч, эмнэлгийн ажилтны тоо нэмэгдсээр байна. Ийнхүү хуучныг өөрчлөн, шинэ соёлыг бий болгох талаар үлэмж үр дүнд хүрэхийн хирээр лаосын хөдөлмөрчдийн амьдрал байнга дээшилж байна.

Нийгэм-эдийн засаг, соёлыг хөгжүүлэх талаар лаосын ард түмний олсон дээрх ололт нь ЛАХН-ын марксист-ленинист бодлого, үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм.

ЛАХН улс орноо ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй хөгжүүлэх талаар асар их анхаарал тавьж байна. Үүний нэг томоохон жишээ бол энэ оны тавдугаар сарын эхээр төлөвлөлтийн асуудлаар хуралдсан үндэсний анхдугаар бага хурлаар улс ардын аж ахуйг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөний урьдчилсан дүн, 1986-1990 онд хөгжүүлэх II таван жилийн төлөвлөгөөний үндсэн зорилт болон улс орныг 2000 он хүртэл хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөний төслийн үндсэн чиглэлийн тухай асуудал хэлэлцсэн явдал юм.

БНАЛАУ-ын нам, засгийн төлөөлөгчид 1976 онд ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад албан ёсны найрсаг айлчлал хийж, эдийн засаг шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулсны үр дүнд тус улсаас социалист орнуудтай тогтоосон улс төр, эдийн засгийн харилцаа чанарын шинэ шатанд оров.

ЛАХН-ын тууштай энх тайванч гадаад бодлого амжилттай хэрэгжиж байгаагийн үр дүнд олон улсын тавцан дээр БНАЛАУ-ын нэр хүнд хэлбэрэлтгүй өсөв. БНАЛАУ даян дэлхийд энх тайвныг бэхжүүлэх, зэвсэг хураах, дэлхийн шинэ дайны аюулыг зайлуулахад чиглэсэн ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орны үр бүтээлтэй санаачилгыг идэвхтэй дэмждэг юм. Тус улс БНСВУ, БНКАУ-ын хамтаар хөрш зэргэлдээ бүх оронтой найрсаг харилцаа тогтоох, Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдлын бүс болохын төлөө тууштай тэмцэж, империалист болон жанжлагч хүчний бодлого, ажил явууллагыг эрс шийдвэртэй эсэргүүцэж байна.

МАХН, ЛАХН болон БНМАУ, БНАЛАУ-ын хоорондын ах дүүгийн найрамдал, нягт хамтын ажиллагаа марксизм-ленинизм, социалист интернационализмын зарчимд тулгуурлан амжилттай хөгжиж байна.

БНМАУ, БНАЛАУ-ын ах дүүгийн харилцаа, хамтын ажиллагаа нь хоёр улсын засгийн газар хоорондын найрамдал, хамтын ажиллагааны тухай 1979 оны гэрээний дагуу өргөжин гүнзгийрсээр байна.

1985 онд Лаосын ард түмэн ах дүү Вьетнам, Кампучийн ард түмэн дэлхийн дэвшилт хүчний хамт ЛАХН байгуулагдсаны 30 жил, БНАЛАУ-ыг тунхагласны болон Энэтхэг-Хятадын хойгт Америкийн түрэмгийлэгчид, тэдгээрийн гар хөл бологчдыг ялсны 10 жилийн түүхт ойнуудыг тэмдэглэж байна.

<sup>5</sup> “Үнэн” 1985.III.22

Лаосын ард түмэн ЛАХН-ын III их хурлаас улс орныхоо нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг амжилттай хэрэгжүүлж байгаад Монголын ард түмэн чин сэтгэлийн баяр хүргэж байна.

Ц.Баатар

ЛАОС: ПО ПУТИ СОЦИАЛЬНОГО ПРОГРЕССА  
( к 10-й годовщине провозглашения ЛНДР)

Резюме

Путь к новой жизни страна начала в декабре 1975 года, являясь полуфеодальной и крайне отсталой. Творчески оценивая обстановку, III съезд Народно-революционной партии Лаоса, проходивший в апреле 1982 года, в качестве первоочередной наметил задачу постепенного перевода сельского хозяйства на социалистический путь развития и решения продовольственной проблемы. Ставилась также задача создания современной инфраструктуры для увязки национального хозяйственного механизма в единое целое. Одновременно развертывалась электрофикация страны. С наращиванием экономического потенциала набирала силу и социальная перестройка, шло формирование социалистического сектора в экономике. Первые успехи приносит преобразование не социалистических секторов в народном хозяйстве, в первую очередь кооперация сельского хозяйства, 37 процентов крестьян вступили в 2400 коллективные хозяйства, которые занимают 35 процентов всей посевной площади страны. 74300 га полей имеют ирригационную систему. По всей стране успешно ликвидируется неграмотность. Значительные результаты были достигнуты в области преобразования старой и формирования новой культуры. Жизнь лаосских трудящихся постепенно улучшается.

В настоящее время лаосский народ претворяет в жизнь решения VII Пленума (1985) ЦК НРПЛ с целью реализовать план последнего года 1 пятилетнего плана на встречу предстоящего IV съезда партии.

Укрепляя традиционную солидарность, дружбу и сотрудничество с народами Вьетнама и Кампучии, а также братскую дружбу и всестороннее сотрудничество с Советским союзом и другими странами социалистического содружества и развивая связи с другими государствами мира, лаосский народ под руководством НРПЛ строит социализм в стране и вносит свой активный вклад в дело сохранения мира и стабильности в Юго-Восточной Азии и во всем мире.